



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/38

Арвайхээр


Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Аймгийн 2020 оны төсөв батлах тухай” 12/09 дугаар тогтоолын 9 дүгээр зүйл, Эрүүл Мэндийн Сайд, аймгийн Засаг дарга нарын 2020 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний 3 дугаар зүйлийн 3.2.2.4, 3.2.6.4 дүгээр заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хархорин өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын засварын үлдэгдэл 47.413.136 (дөчин долоон сая дөрвөн зуун арван гурван мянга нэг зуун гучин зургаа) төгрөг, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуульд сэргээн засах чиглэлээр суралцсан 8 эмнэлгийн мэргэжилтний сургалтын төлбөр 1.830.400 (нэг сая найман зуун гучин мянга дөрвөн зуу), Сант, Төгрөг сумын Эрүүл мэндийн төвийн Эрүүл мэндийн даатгалын мэдээлэл боловсруулахад шаардлагатай зөөврийн компьютер 2.390.000 (хоёр сая гурван зуун ерэн мянга) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх 52.173.536 (тавин хоёр сая нэг зуун далан гурван мянга таван зуун гучин зургаа) төгрөгийн зардлыг Эрүүл мэндийн тусгай зориулалтын шилжүүлгийн Арвайхээр өрхийн эмнэлгийн 2020 оны төсвөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр), Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100079